



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
(САИНН)-ын нэр болон дүрмийн өөрчлөлт,
намын даргыг улсын бүртгэлд бүртгэхээс
татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Х.Батсүрэн, М.Батсуурь, Н.Баярмаа, Н.Батзориг, Н.Батчимэг, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын нэр болон дүрмийн өөрчлөлт, намын даргыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Д.Батбаатарын илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг төлөөлж иргэн Б.Жагар 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Улсын дээд шүүхэд өргөдөл гаргасан.

Уг өргөдөлд “... Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын нэрийг Сайн ардчилсан нам болгож өөрчлөх, Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д намын дүрмийг нийцүүлснийг бүртгүүлэх, намын дарга Бямбасүрэнгийн Жагарын нэрийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгаж, бүртгэж өгнө үү” гээд нийт 164 хуудас, 1 ширхэг флаш, 1 ширхэг (DVD) материал ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтууд нь Улс төрийн намын тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын хавсралт №5А-д заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, журмын 6.6-д зааснаар Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргасны дагуу хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын нэр болон дүрмийн өөрчлөлт, намын даргыг дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Нэг.Намын ээлжит бус Их хурлын тухайд:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын Монгол Улсын дээд шүүхэд бүртгэлтэй дүрмийн 6.3-т “Намын Их хурал хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг Бага хурлын шийдвэрээр тогтооно”, 6.9.1-д “Намын даргын саналаар болон Намын Бага хурлын гишүүдийн гуравны хоёрын саналаар намын ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулна” гэж заасны дагуу тус намын Бага хурлын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 25/01 дүгээр тогтоолоор намын ээлжит бус Их хурлыг 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хуралдуулахаар тогтоосон боловч намын ээлжит бус Их хурлын төлөөлөгчдийг сонгох талаарх тус намын дүрмийн 6.10-т “Намын Их хуралд орон нутаг, нийслэлээс сонгогдсон төлөөлөгчдөөс гадна, намын Бага хурлын шийдвэрээр томилогдсон Намын дүрэм, ёс зүйн ерөнхий хорооны гишүүд, Удирдах зөвлөлийн гишүүд оролцоно”, 15.5.12-т “Намын Их хуралд орон нутгийн төлөөлөл буюу аймгуудын намын хорооноос нийт 21 ба түүнээс доошгүй сондгой тооны төлөөлөгч байна”, 15.5.14-т “Намын Их хуралд нийслэлийн намын хорооноос нийт 11 ба түүнээс доошгүй сондгой тооны төлөөлөгч байна” гэх заалтуудыг биелүүлж тухайн хуралд оролцох төлөөлөгчдийг бүрдүүлээгүй байна.

Өөрөөр хэлбэл ээлжит бус Их хуралд орон нутаг, нийслэлээс сонгогдсон болон Бага хурлын шийдвэрээр томилогдон оролцох төлөөлөгчдийн тоог намын дүрмийн дагуу бүрдүүлээгүйгээс гадна, хурлын ирцийн бүртгэл, тэмдэглэл зэрэгт тусгагдсан 45 төлөөлөгчийг хаанаас, хэрхэн сонгож, томилсон нь тодорхойгүй байгаа нь намын дүрмийн дээрх заалтуудыг зөрчсөн гэх үндэслэл болно.

Мөн ээлжит бус Их хуралд оролцсон төлөөлөгчийн нэрсийг Монгол Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй тус намын хувийн хэрэгт авагдсан 801 гишүүний бүртгэл болон шинээр элссэн гишүүдийн бүртгэлтэй тулгаж үзэхэд 28 төлөөлөгчийн нэрсээс бусад нь тохирохгүй байна.

Эдгээрээс үзэхэд намын 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус Их хурал, түүнээс гаргасан шийдвэрүүдийг хүчин төгөлдөр гэж үзэх боломжгүй тул Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын нэр болон дүрмийн өөрчлөлт, намын даргыг бүртгүүлэх хүсэлтийг хангахаас татгалзахаар шийдвэрлэв.

Хоёр.Намын дүрмийн өөрчлөлтийн тухайд:

Урьд тус намын дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг хэлэлцсэн Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 37 дугаар тогтоолд анхаарах шаардлагатай асуудлуудыг тухайлан дурдсан бөгөөд 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр тус намаас ирүүлсэн дүрмийн өөрчлөлтөд тухайн тогтоолд заасан зарим зөрчлийг арилгасан боловч бүрэн арилгаагүй.

Тухайлбал үндэслэх хэсгийн 1.11-д “Түүнчлэн хуулийн 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна” гэсэн санхүүжилтийг салбар, нэгжид хуваарилах асуудлыг намын дүрэмд тусгаагүй, орхигдуулжээ” гэж дурдсан нөхцөл байдал хэвээр байна.

Намын дүрмийн 16.20-д “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг намын төв байгууллагад хүлээж авсны дараа намын бүтцийн байгууллагад дараах харьцаагаар хуваарилна”, 16.20.1-д “Энэ дүрмийн 16.3.1, 16.3.2, 16.3.3-т заасан зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр салбар, Бодлогын судалгааны байгууллагаас Намын ажлын албанд ирүүлсэн төслийг санхүүжүүлэхэд 50 хувь”, 16.20.2-т “Намын ажлын албыг болон ажлын албанаас санхүүжүүлэхээр энэхүү дүрэмд тусгагдсан намын бүтэц, ажлын хэсгийн үйл ажиллагаа, намаас нэгдсэн журмаар зохион байгуулах үйл ажиллагааг тус тус санхүүжүүлэхэд 50 хувь” гэж өөрчлөлт оруулж бүтцийн нэгжид төрөөс үзүүлэх санхүүжилтийг хуваарилах талаар тусгасан боловч намын салбарт хуваарилах асуудлыг зохицуулаагүй, хэрэв төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг салбарт хуваарилах зохицуулалтыг хэрэглэхгүй гэж үзвэл намын дүрэмд үндэслэлээ тодорхой тусгах нь зүйтэй, үүнээс гадна тухайн заалтуудын “50 хувь” гэсэн нь төрөөс үзүүлсэн санхүүгийн дэмжлэгийн эсхүл төсөл хөтөлбөрт шаардагдах санхүүжилтийн хувийг заасан эсэх нь ойлгомжгүй байна.

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар “Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл” тул үйл ажиллагаандаа бүх гишүүдийн оролцоог хангах, хамтын зарчмаар асуудлыг шийдвэрлэдэг байх ёстой.

Энэ зарчмыг мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно”, 8.4-т “Намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон сонгуульд нэр дэвшигчийг санал болгоход намын гишүүдийн оролцоог хангаж, саналыг сонсоно” гэж тодорхой хуульчилжээ.

Гэтэл тус нам дүрмийнхээ 6.6.1-6.6.13-т намын удирдах дээд байгууллага болох Их хурлын онцгой бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлыг тусгаж, намын удирдах дээд байгууллагын бүрэлдэхүүнийг тогтоохдоо намын дүрмийн 6.4-т “Намын Их Хурал нь 27 ба түүнээс дээш сондгой тооны сонгогдсон болон томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэх буюу тэдгээрийн гуравны хоёроос доошгүй төлөөлөгч хүрэлцэн ирснээр намын Их хурлыг хүчинтэйд тооцно” гэж Их хурлын гишүүдийн тоог одоо хүчин төгөлдөр байгаа дүрэмд зааснаас бууруулж тогтоосон нь хуулийн дээрх заалтуудад нийцэхгүй байна.

Тодруулбал, намын Их хурал 27 гишүүнтэй, үүнээс 18 гишүүн хуралд ирснээр аливаа асуудлыг хянан шийдвэрлэх нь намын гишүүдийн оролцоог хангах хуулийн заалтад нийцэж байгаа эсэхийг анхаарвал зохино.

Гурав.Намын даргын нэрийг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгаж, бүртгүүлэх тухайд:

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын даргыг бүртгүүлэх тухай хүсэлтийг хуульд заасан журмын дагуу гаргаагүй байна.

Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т “... намын даргыг томилсон шийдвэрийг 60 хоногийн дотор Улсын дээд шүүхэд албан ёсоор хүргүүлнэ.” 17.6-д “Намын дүрэмд заасны дагуу намын даргыг удирдах дээд

байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага, ... тус тус сонгоно”, Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 6.4-т “Намын даргыг томилсон шийдвэр гарснаас хойш 60 хоногийн дотор тухайн намын өмнөх дарга, эсхүл намын даргыг сонгох эрх бүхий удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч шинээр томилогдсон даргыг бүртгүүлэх тухай хүсэлтийг журмын Хавсралт №6, 6А-д заасан бүрдлийг хангаж Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.” гэж тус тус зааснаар холбогдох баримтыг бүрэн гүйцэд бүрдүүлж, Улсын дээд шүүхэд хандах учиртай.

Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрмийн 6.6-д “Намын Их хурал нь бодлогын үндсэн асуудлыг хэлэлцэн, онцгой бүрэн эрхийн хүрээнд дараах асуудлыг шийдвэрлэнэ”, 6.6.2-т “Намын даргыг сонгох, чөлөөлөх”, 8.2-т “САИН намын даргыг Их хурлаас 4 жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгох бөгөөд намын дарга улиран сонгогдож болно” гэж заажээ.

Түүнчлэн тус нам анх 2021 оны 12 дугаар сарын 12-ны өдөр нам үүсгэн байгуулах Их хурлаа хийж 10 дугаар тогтоолоор Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын даргын санал хураалтад олонхын санал авсан Бямбасүрэн овогтой Жагарыг Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн намын даргаар сонгогдсонд тооцож баталсан боловч намын даргыг бүртгүүлэх тухай хүсэлтийг гаргаагүй, харин нам үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр гаргасныг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар тогтоолоор улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан байна.

Улмаар Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг үүсгэн байгуулсныг бүртгүүлэхээр дахин өргөдөл гаргасныг Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 14, 20, 30, 39 дүгээр тогтоолуудаар тус тус татгалзаж шийдвэрлэжээ.

Харин Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 22 дугаар тогтоолоор Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ыг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн боловч тухайн намаас хүсэлт гаргаагүйгээс намын даргыг улсын бүртгэлд бүртгээгүй байна.

Намын ээлжит бус Их хурал 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр хуралдан намын дарга Бямбасүрэнгийн Жагарын нэрийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгаж, бүртгүүлэх 25/08 дугаар тогтоол ирүүлсэн боловч өргөдөл болон түүнд хавсаргасан баримтуудад ээлжит бус Их хурлаас намын даргыг сонгох асуудлыг Улс төрийн намын тухай хууль болон Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын дүрэмд заасны дагуу хэлэлцэж шийдвэрлэсэн талаарх баримт хавсаргагдаагүй.

Иймд дээр дурдсан болон бусад асуудлуудыг сайтар нягтлан, Улс төрийн намын тухай хууль болон намын дүрэмд нийцүүлж хуралдсан намын удирдах дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн өргөдлийг ирүүлэх шаардлагатайг анхааруулах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас дүгнэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам (САИНН)-ын нэр болон дүрмийн өөрчлөлт, намын даргыг бүртгэхээс татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Д.БАТБААТАР